210402	Тээвэр, шатахуун	0.00	12,626,800.00	(12,626,800.00)
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	0.00	112,500.00	(112,500.00)
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	0.00	480,000.00	(480,000.00)
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	9,394,000.00	(9,394,000.00)

20

УБС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

ХЯЗГААРТАЛГАА
САНАЛ ДҮГНЭЭЛ

210901	Баргаа үйлчилгээний бусад зардал	0.00	9,394,000.00	(9,394,000.00)
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0.00	150,000,000.00	(150,000,000.00)
2200	Дотоод эх үүсвэрээр	0.00	150,000,000.00	(150,000,000.00)
223001	Бусад хөрөнгө	0.00	150,000,000.00	(150,000,000.00)
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	0.00	173,598,000.00	(173,598,000.00)
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	0.00	173,598,000.00	(173,598,000.00)
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	152,000,000.00	(152,000,000.00)
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	21,598,000.00	(21,598,000.00)

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Улаангом сумын Засаг даргын тамгын газар нь иргэдэд төрийн үйлчилгээг шуурхай, чанартай, хүртээмжтэй хүргэх гэсэн зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилгоо тодорхойлон ажиллажээ.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- ✓ Хөдөлмөрийн тухай хууль - Шинэчлэн найруулгыг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөж эхэлсэн.
- ✓ Төрийн хэмнэлтийн тухай хууль 2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр батлагдсан.
- ✓ Төрийн албаны тухай хуульд 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр, 7 дугаар сарын 05-ны өдөр, 11 дүгээр сарын 11-ний өдөр нэмэлт өөрчлөлтүүд оруулсан байна.
- ✓ Төсвийн тухай хуульд 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр, 7 дугаар сарын 01-ний өдөр, 8 дугаар сарын 29-ний өдөр, 11 дүгээр сарын 11-ний өдөр тус тус нэмэлт өөрчлөлт оруулсан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчаас эрсдэлд суурилсан дотоод аудит хийсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ

УБС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
20 ХЯЗГААРСАЛТАА
САВАЛ ДҮГНЭЛТ

илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Улаангом сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Улаангом сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Улаангом сумын 2022 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,454,480.3 мянган төгрөгөөр буюу 5.3 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөг/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0	0	
Авлага	10,330.9	100.0	-10,230.9
Бараа материал	277,054.3	295,290.8	18,236.5
Үндсэн хөрөнгө	27,272,247.2	25,803,297.4	-1,468,949.8
Нийт хөрөнгө	27,559,632.5	26,098,688.2	-1,460,944.3
Өр төлбөр	3,751.5	100.0	-3,651.5
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	27,555,880.9	26,098,588.2	-1,457,292.7
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	27,559,632.5	26,105,152.2	-1,460,944.3

Авлага дансны үлдэгдэл 100.0 мянган төгрөг болж 10,230.9 төгрөгөөр буурсан нь НДШ-ын авлага, хувь хүнээс авах цахим худгийн картын авлага барагдсанаас шалтгаалжээ.

Бараа материалын дансны үлдэгдэл 295,290.8 мянган төгрөг болж 24,700.5 мянган төгрөгөөр өссөн нь аж ахуйн материал, мал амьтад нэмэгдсэнээс шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 25,803,297.4 мянган төгрөг болж 1,468,949.8 мянган төгрөгөөр буурсан нь төсвийн хөрөнгөөр 41,934.7 мянга, үнэ төлбөргүй авсан 3,528,637.7 мянга, акталсан 181,965.2 мянга, балансаас балансад шилжүүлсэн 24,830.0 мянган төгрөг, тайлант оны элэгдэлтэй холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 26,105,052.2 мянган төгрөг болж 1,450,480.3 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 1,156,872.9 төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

УВС АЙЛАГ ДАХЬ ТӨР АЖ АХУЙН ТӨСВИЙН ХАРИУЦАГЧИЙН ХАМГААГАХ ХАНАГАА
 30 ХАМГААГАХ ХАНАГАА
 САНХҮҮГИЙН ХАНАГАА

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 169,207.1 мянган төгрөгөөр бууруулж 987,665.8 мянган төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөр, 15 арга хэмжээг санхүүжүүлэхээр орон нутгийн төсвөөс 1,392,291.4 мянга, үйл ажиллагааны орлогоос 14,000.0 мянган төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 1,392,291.4 мянга, үйл ажиллагааны орлого 15,408.9 мянга, нийт 1,407,700.3 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 1,326,232.1 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,326,323.1 мянган төгрөг буюу 97.8 хувьтай байгаа нь зардлыг 80,059.5 мянган төгрөгөөр хэмнэж, үндсэн үйл ажиллагааны орлого 1,408.9 мянган төгрөгөөр илүү бүрдэж, нийт 81,468.2 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	70106-ОН-ын гүйцэтгэх засаглалын удирдлага 80101- Үндсэн үйл ажиллагааны зардал	547,675.00	503,868.00	43,807.00	92.0%
2	70106-ОН-ын гүйцэтгэх засаглалын удирдлага 80106- Баг, хорооны ҮА Зардал	347,264.00	324,021.20	23,242.80	93.3%
3	70106-ОН-ын гүйцэтгэх засаглалын удирдлага 80111- Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	143,677.10	131,673.20	12,003.90	91.6%
4	70106-ОН-ын гүйцэтгэх засаглалын удирдлага 80112- Нийтлэг үйлчилгээ	122,374.10	121,992.70	381.40	99.7%
5	70106-ОН-ын гүйцэтгэх засаглалын удирдлага 80205- Мэдээлэл, сурталчилгааны зардал	5,400.00	5,400.00	0.00	100.0%
6	70106-ОН-ын гүйцэтгэх засаглалын удирдлага 80403- Нийтийн тээврийн алдагдалд олгох татаас	28,000.00	28,000.00	0.00	100.0%
7	70106-ОН-ын гүйцэтгэх засаглалын удирдлага 80802- Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал	109,435.40	109,349.30	86.10	99.9%
8	70106-ОН-ын гүйцэтгэх засаглалын удирдлага 80815- Сонгуулийн үр дүнгээр чөлөөлөгдсөн	41,843.30	41,843.28	0.02	100.0%
9	70106-ОН-ын гүйцэтгэх засаглалын удирдлага 80918- Бусад	15,000.00	14,598.70	401.30	97.3%
10	70106-ОН-ын гүйцэтгэх засаглалын удирдлага 81102- Орон нутгийн нөөц хөрөнгө	33,000.00	32,867.90	132.10	99.6%
11	70106-ОН-ын гүйцэтгэх засаглалын удирдлага 81507- Мал тооллого	2,300.00	2,300.00	0.00	100.0%
12	70106-ОН-ын гүйцэтгэх засаглалын удирдлага 81701- Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх	3,122.50	3,117.60	4.90	99.8%
13	70106-ОН-ын гүйцэтгэх засаглалын удирдлага 82212- Хур хог хаягдал, орчны бохирдол	2000	2000	0.00	100.0%

20

ХТЭЗҮМЭРГЭЛЭН
САНАА АНГАА

14	70106-ОН-ын гүйцэтгэх засаглалын удирдлага 82801- Улсын их баяр наадам	4,000.00	4,000.00	0.00	100.0%
15	72208- Ахмад настны хөгжил хамгаалал, 81549- Ахмадын сан	1,200.00	1,200.00	0.00	100.0%
		1,406,291.4	1,326,231.9	80,059.5	94.3%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	70106-ОН-ын гүйцэтгэх засаглалын удирдлага 80101-Үндсэн үйл ажиллагааны зардал	0.00	17,698.0	17,698.0	100%
2	70106-ОН-ын гүйцэтгэх засаглалын удирдлага 80918- Бусад	0.00	150,000.0	150,000.0	100%
3	70106-ОН-ын гүйцэтгэх засаглалын удирдлага 83201- Ангилагдаагүй бусад зориулалт	0.00	5,900.0	5,900.0	100%

Нэмэлт санхүүжилтийн дансаар аймгийн ИТХ-аас 3,900.0 мянга, Засаг даргын нөөц хөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөцөөс 14,770.0 мянга, аймгийн ОНХС-аас 150,000.0 мянган төгрөг ХЭЭГБХТ төслөөс 4,928.0 мянга, нийт 173,598.0 мянган төгрөгийн нэмэлт санхүүжилт авч төлөвлөсөн үйл ажиллагаанд зарцуулсан байна.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант онд ХЭЭГБХТ төслөөс 2020 оны үлдэгдэл санхүүжилт 4,928.0 мянга төгрөгийг хүүхэд эмэгтэйчүүдийн эсрэг, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр төсөл хөтөлбөр хэрэгжүүлэн нэмэлт санхүүжүүлэлтийн дансаар дамжуулан зориулалтын дагуу зарцуулсан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Улаангом сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Р.Аюуш гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Улаангом сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 1/15 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 0.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар тооцож 6,193.5 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн. Гүйцэтгэлийн үе шатанд 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 6,593,569.2 мянган төгрөгийн 0,5 хувь буюу 32,967.8 мянган төгрөгөөс 80 хувиар тооцож 26,374.3 мянган төгрөгөөр тогтоолоо.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Улаангом сумын Засаг даргын тамгын газрын тухайн хуульд хамаарах зүйл заалтын хүрээнд горим сорил хэрэгжүүлсэн. Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэн ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд www.shilendans.gov.mn цахим хуудсанд оруулбал зохих 151 мэдээллээс хугацаандаа оруулсан 146, хугацаа хоцроож байршуулсан 3, хугацаа болоогүй хүлээгдэж байгаа 2 мэдээлэл байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хэрэгжилт

Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.5 дахь хэсэгт “Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй” гэж заасныг Улаангом сумын Засаг даргын тамгын газар нь тайлант хугацаанд бүрэн хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Улаангом сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийгээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар 16,126.1 мянган төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт тогтоосон байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	16,126.1			
Албан шаардлага					
Зөвлөмж					
Нийт дүн	1	16,126.1			

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар тогтоосон Улаангом сумын Засаг даргын тамгын газар Засаг даргын орлогчийн 1 орон тоон дээр 2 орлогч ажиллуулж 16,126.1 мянган төгрөгийн цалинг илүү олгосныг төлүүлэхээр төлбөрийн акт тогтоосон ч төлбөрийн актыг эс хүлээн зөвшөөрөлгүй Захиргааны хэргийн анхан шатны шүүхэд хандаж, Захиргааны хэргийн анхан шүүхээс төлбөрийн актыг түдгэлзүүлсэн маргаантай байгаа учраас биелэгдээгүй байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 37,594.0 мянган төгрөгийн 2 зөрчил¹ илэрснээс 12,349.0 мянган төгрөгийн албан шаардлага өгч, 25,245.0 мянган төгрөгийн 1 зөвлөмж хүргүүлээ.

5.2 Албан шаардлага

1. Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх заалтад “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.1 дэх заалтад “Төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах”, Төрийн албаны тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1 дэх заалтад “Төрийн албан хаагч хуульд зааснаас гадна дараахь үйл ажиллагаа явуулахыг хориглоно”, 39.1.3 дахь заалтад “Хуульд нийцээгүй шийдвэр гаргах”, 12 дугаар зүйлийн Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэгт “Энэ хуулийн 3.1-д заасан этгээдэд дараах зориулалтаар зардал санхүүжүүлэх, зарцуулахыг хориглоно”, 12.1.4-д “Хуулиар зөвшөөрөөгүй бусад”, 15 дугаар зүйлийн 15.2.3 дахь заалтад “Сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж, бичиг хэрэг, тээвэр шатахуун, дотоод албан томилолт болон холбогдох бусад зардлыг хэмнэх”, Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 2 дугаар сарын 17-ны өдрийн 43 дугаар тогтоолын 1.5 дахь хэсэгт “Салбарын хэмжээнд хийх сургалт, семинар, хурал, зөвлөгөөн болон газар дээрх хяналт-шалгалт зэргийг цахим хэлбэрээр зохион байгуулж, сургалт, семинар, хурал, зөвлөгөөн зэрэг арга хэмжээний болон дотоод албан томилолтын зардлыг хэмнэх” гэж заасныг тус тус зөрчин эрх бүхүй албан тушаалтан, байгууллагын удирдамж, хөтөлбөр, томилолтын тайлан, илтгэх хуудасгүйгээр албан томилолтын зардал гаргасан байна. Үүнд:

- 1.1. Улаангом сумын Засаг даргын тамгын газар нь 2022 онд Хөвсгөл аймгийн Мөрөн суманд Багийн Засаг дарга, ЗДТГ-ын 12 мэргэжилтний томилолтын зардалд 4,248.0 мянган төгрөг, замын зардалд 800.0 мянган төгрөг зарцуулсан.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

- 1.2. Тэс суманд ЗДТГ-ын 20 албан хаагчдын томилолтын зардалд 3,840.0 мянган төгрөг зарцуулсан.
- 1.3. Цагаанхайрхан суманд 3 мэргэжилтний томилолтын зардалд 621.0 мянган төгрөг зарцуулсан.
- 1.4. ОХУ-ын Тува Красноярскийн хязгаарын Курагино районд эрх бүхий албан тушаалтан байгууллагын шийдвэрийн дагуу тусгайлсан хөтөлбөргүй, албан ёсны гэрээ хэлцэл байхгүй, томилолтын тайлан, илтгэх хуудасгүй 4 албан хаагчийн 2,840.0 мянган төгрөг, нийт 12,349.0 мянган төгрөгийн албан томилолтын зардал олгосонд зөрчлийг таслан зогсоохыг албан шаардлага болголоо.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1.1. Илрүүлэлт:

Сангийн сайдын 2012 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 276 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан “Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам”-ын 2.3-д “Журмын 2.2-д зааснаас бусад зардлаас зайлшгүй бэлнээр гүйлгээ хийлгэх шаардлагатай тохиолдолд албан хүсэлт, зайлшгүй бэлнээр гүйлгээ хийлгэх шаардлагатай тохиолдолд албан хүсэлт, шаардлагатай хөрөнгийн баталсан төсөв, бэлнээр авах үндэслэлийг тодорхой тусгаж ирүүлнэ. Төрийн сан албан хүсэлтийг хянаж үзэн, шаардлагатай гэж үзвэл бэлнээр олгож болно”, 3.8-д “Мөнгөн кассын нярав нь анхан шатны орлого, зарлагын баримтыг үндэслэн мөнгөн кассын гүйлгээг хийнэ”, 8.3-д “Энэ журмын 2.5-д заасан үйл ажиллагаанд тухайн байгууллагын төсвийн эрх захирагч, нягтлан бодогч нар хяналт тавьж ажиллана” гэж заасныг тус тус зөрчин 25,245.0 мянган төгрөгийн гүйлгээг анхан шатны баримтын бүрдэлгүй, нярвын дансаар дамжуулан зарцуулсан зөрчил илэрсэнд зөвлөмж өглөө.

1.2. Өгсөн зөвлөмж:

Цаашид Сангийн сайдын 2012 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 276 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам”-ыг хэрэгжүүлэн ажиллах.

Дээрх албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг хангаж, нотлох баримтын хамт 2023 оны 3 дугаар сарын 25-ны өдрийн дотор манай байгууллагад ирүүлнэ үү.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/ Үүнээс										
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Баримтын бүрдэл дутуу томилолтын зардал гаргасан	1	12,349.0			1	12,349.0							

УБС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
20 ХЯЗГААРЛАЛТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ

Мөнгөн кассын журам зөрчсөн	1	25.245.0				1	25.245.0			
Дүн	2	37,594.0			1	12,349.0	1	25.245.0	-	

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Дүн								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн								

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбоодод тус тусад нь танилцуулга тайлбар хэлэлцүүлэг илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР /М.БАТСУУРЬ/

АУДИТЫН МЕНЕЖЕР

/М.БАТ-АМГАЛАН/

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР

P. Bay



2023 оны 02 сарын 25-ны өдөр



**УВС АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА**

2023 оны 02 сарын 28 өдөр

Дугаар 01/19/02070457

Улаангом

УВА - 2023/17/НА - СТА - ТУЛЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Улаангом сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. Улаангом сумын Засаг даргын тамгын газар нь 2022 онд ажлын удирдамж, хөтөлбөр, томилолтын тайлан, илтгэх хуудасгүйгээр Хөвсгөл аймгийн Мөрөн суманд Багийн Засаг дарга, ЗДТГ-ын 12 мэргэжилтний томилолтын зардалд 4,248,000 төгрөг, замын зардалд 800,000 төгрөг зарцуулсан.
2. Тэс суманд ЗДТГ-ын 20 албан хаагчдын томилолтын зардалд 3,840,000 төгрөг зарцуулсан.
3. Цагаанхайрхан суманд 3 мэргэжилтний томилолтын зардалд 621,000 төгрөг зарцуулсан.
4. ОХУ-ын Тува Красноярскийн хязгаарын Курагинно районд эрх бүхий албан тушаалтны шийдвэрийн дагуу тусгайлсан хөтөлбөргүй, албан ёсны гэрээ хэлцэл байхгүй, томилолтын тайлан, илтгэх хуудасгүй 4 албан хаагчийн 2,840,000 төгрөг, нийт 12,349,000 төгрөгийн дотоод албан томилолтын зардал олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх заалтад "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөх, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.1 дэх заалтад "Төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах", Төрийн албаны тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1 дэх заалтад "Төрийн албан хаагч хуульд зааснаас гадна дараахь үйл ажиллагаа явуулахыг хориглоно", 39.1.3 дахь заалтад "Хуульд нийцээгүй шийдвэр гаргах", 12 дугаар зүйлийн Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэгт "Энэ хуулийн 3.1-д заасан этгээдэд дараах зориулалтаар зардал санхүүжүүлэх, зарцуулахыг хориглоно", 12.1.4 дэх хэсэгт "Хуулиар зөвшөөрөөгүй бусад", 15 дугаар зүйлийн 15.2.3 дахь заалтад "Сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж, бичиг хэрэг, тээвэр шатахуун, дотоод албан томилолт болон холбогдох бусад зардлыг хэмнэх", Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 2 дугаар сарын 17-ны өдрийн 43 дугаар тогтоолын 1.5 дахь хэсэгт "Сагсарын хэмжээнд хийх сургалт, семинар, хурал, зөвлөгөөн болон газар дээрх хяналт шалгалт зэргийг цахим хэлбэрээр зохион байгуулж, сургалт, семинар, хурал, зөвлөгөөн зэрэг арга хэмжээний болон дотоод албан томилолтын зардлыг хэмнэх" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1-д “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана”, 4.2.1.1 дэх заалтад “Нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж баталгаажаагүй”, 4.2.1.11-д “Хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэж заасныг тус тус үндэслэн ШААРДАХ нь:


1. Хууль, тогтоомжийг мөрдөн ажиллаж, биелэлтийг 2023 оны 3 дугаар сарын 30-ны өдрийн дотор Увс аймаг дахь Төрийн аудитын газар² т ирүүлэх.
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Улаангом сумын ЗДТГ-ын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Ганхуяг, нягтлан бодогч Б.Майцэцэг нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Р.АЮУШ

М.БАТ-АМГАЛАН

М.БАТСУУРЬ